

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/21

Арвайхээр


Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.1 дэхь заалт болон Засаг даргын Тамгын газрын даргын “Тендерийг хүчингүй болгох тухай” 2020 оны А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, Есөнзүйл сумын сум дундын эмнэлэг, Сумын эрүүл мэндийн төвүүдэд 2020 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал нийлүүлэгчээс үнийн санал ирүүлсэн “Багц-4 Уламжлалт анагаах ухааны эм” 4797073 (дөрвөн сая долоон зуун ерэн долоон мянга далан гурав) Одь тан ХХК-аар, “Багц-6 Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм” 4851800 (дөрвөн сая найман зуун тавин нэгэн мянга найман зуу) Ази фарм ХХК, “Багц-15 Амин дэм, эрдэс бодисууд” 13498330 (арван гурван сая дөрвөн зуун ерэн найман мянга гурван зуун гуч) Ази фарм ХХК-аар, “Багц-16 Дотоодод үйлдвэрлэгдсэн антибиотикүүд” 6203450 (зургаан сая хоёр зуун гурван мянга дөрвөн зуун тавь) төгрөгөөр Ази фарм ХХК-уудтай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Ю.Ичинноров)-д, гэрээний дагуу нийлүүлэх хуваарь санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, нийтлэг үйлчилгээний албаны дарга (Б.Валя)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

1500000000